



“ӨСВӨР ҮЕ ХҮНС”  
ОНӨААТҮГ

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв Мян.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ - лийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	<b>Стратегийн төлөвлөгөөний зорилго 1.</b> Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана. <b>НЗДҮАХ-2.3.5.</b>						
1.	Арга хэмжээ 1. Баянзүрх, Хан-Уул дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийг эрүүл ахуйн чанар, стандарт хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр		Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанараас үүдсэн хоолны хордлого гаргахгүй ажиллах	0	0	Харилцагч нийт цэцэрлэг, сургуулиудад эрүүл ахуйн стандарт, шаардлагын дагуу шинжилгээнд бүрэн хамрагдсан 27 төрлийн 110 орчим нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр ажлын өдөр бүр хангаж ажилласан. Тайлант хугацаанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай холбоотой ямар нэгэн гомдол, санал, шүүмжлэл гараагүй байна.	100%

	жилийн турш хангаж ажиллана.		байгууллагын тоо				
1.1.	Арга хэмжээ: Баянзүрх, Хан-Уул дүүргийн 8 цэцэрлэгийн 150-аас доошгүй хичээлийн байрыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан 27 төрлийн 110 орчим нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр тасралтгүй, шуурхай ханган нийлүүлж ажиллана	6,900,000.0	Хүнсний бүтээгдэхүүнээр ханган ажилласан цэцэрлэгийн тоо	83	83	2023 онд цэцэрлэгүүд шинээр баригдаж ашиглалтад орсноор 2 дүүргийн 96 цэцэрлэг, тэдгээрийн салбаруудын хамт нийт 175 хичээлийн байр, 20 ерөнхий боловсролын сургуулийг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан 27 төрлийн 110 орчим нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр ажлын өдөр бүр түгээлтийн 5 машинаар тасралтгүй, шуурхай ханган нийлүүлж ажилласан.  Эхний 11 сарын байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 7.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 9.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллахаар байна.	100%
1.2.	Арга хэмжээ: Нийлүүлж буй 105 нэрийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд бүрийг эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээнд улирал тутамд хамруулж ажиллана.		I, II, III улиралд шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүний тоо	4 улиралд давхардсан тоогоор 315	4 улиралд 315	Аж ахуй нэгж байгууллагаас шинжилгээ баталгаажилтыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн лабораторид бүтээгдэхүүний эрсдэлээс хамаарч 113 нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар, улирлаар шинжилгээнд хамруулан ажилласан байна. Зөвхөн гэрээт байгууллага болох "Само институт" ХХК-тай хамтран ажиллаж нийт 93 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний шинжилгээнд хамруулан гарч эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Мөн дотооддоо итгэмжлэгдсэн лабораторитой аж ахуй нэгж болох "Том бат" ХХК, "Грийн" ХХК-аас сар бүр шинжилгээнд хамруулж хяналт тавин ажиллалаа. Мөн эрсдэлтэй бүтээгдэхүүн болох хонины мах, үхрийн махыг сар бүр шинжилгээнд хамруулан, гаргал үүслийн бичигтэйгээр хүлээн авч ажилласан.	100%

**Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.

2.1	Арга хэмжээ: Байгууллагын 2023 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын саналыг бэлтгэн Нийслийн Өмчийн харилцааны газраар хянуулсны үндсэн дээр Нийслэлийн Засаг даргаар батлуулж, түүний хэрэгжилтийг Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	7,700,000.0	Төлөвлөсөн ашгийн биелэлтийн хувь	Биелэлт 0%	100%	Байгууллагын 2023 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын саналыг Нийслэлийн Өмчийн харилцааны газраар хянуулсны үндсэн дээр Нийслэлийн Засаг даргаар батлуулсан.  Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 10.8 тэрбум төгрөгийн борлуулалтын үнэ бүхий хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цэцэрлэг сургуульд нийлүүлж ажиллахаар байна. Харин 2023 онд төлөвлөсөн ашгийн биелэлт одоогийн байдлаар 100-аас дээш хувийн гүйцэтгэлтэй гарахаар хүлээгдэж байна.	100%
2.2	Арга хэмжээ: Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн дагуу заасан мэдээ, мэдээллүүдийг хуулийн хугацаанд оруулж, хуулийг хэрэгжүүлснээр иргэдийн мэдэх эрхийг хангана		Жилийн турш оруулсан нийт мэдээллийн тоо	12 сард нийт 148	148	Байгууллагын шилэн дансанд жилийн эцсийн байдлаар 148 мэдээлэл оруулах ёстойгоос одоогоор 133 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулаад байна. Харин 15 мэдээллийг 12 дугаар сар дууссаны дараа, 2024 оны эхэнд оруулах хуулийн хугацаатай байна.	100%
2.3	Арга хэмжээ: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлагыг өмнөх оны түвшингөөс бууруулж ажиллана		Өр, авлага өмнөх оноос буурсан хувь	Өмнөх оноос 70% буурсан	10% багагүй	2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,882,780 төгрөгийн авлага, 36,396,988 төгрөгийн татварын өглөг байснаас эхний хагас жил байдлаар авлага, өр төлбөрөө 100 хувь бүрэн барагдуулсан.  Харин 2023 онд үүссэн НӨАТ-ын өглөгийг 12 сарын 31-ний өдрийн дотор бүрэн барагдуулахаар төлөвлөж байна. Бусад авлага, өр төлбөр байхгүй. Зардлууд зорилтот түвшнөөр батлагдсаны дагуу гарч, Төрийн	100%

						хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулагдаж байна.	
2.4	Арга хэмжээ: Байгууллагын албан хаагчдын 2023 оны сургалтын төлөвлөгөө болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангана.	900.0	Төлөвлөгөө хэрэгсэн хувь	100%	100%	<p>“Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын Ажилтан албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2023-2026 оны хөтөлбөрийг боловсруулж баталсан.</p> <p>Ажилтан албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд 2023 онд ажилтан албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж, Нийслэлийн Өмчийн харилцааны газраар батлуулж, олгосон.</p> <p>Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шинээр 1 өрөө байр худалдан авсан 1 ажилтанд байгууллагын нэг сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон. Ар гэрийн гачигдал тохиолдож гэр бүлийн ойр дотны хүн нь нас барсан 6 ажилтанд нийт нэг сая таван зуун мянга, шинээр хүүхэдтэй болсон 3 ажилтанд нийт нэг сая хоёр зуун мянга, шинээр гэр бүлээ батлуулсан 1 ажилтанд таван зуун мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тус тус олгосон.</p> <p>Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, дархлааг нэмэгдүүлэх зорилгоор спорт заалыг 7 хоног бүр 2 цагийн хугацаатай авахаар “Кайрос” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд 7 хоног бүр спорт зааланд спортоор хичээллэж цагийг зөв боловсон өнгөрүүлж байна.</p> <p>Эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдаагүй байсан 17 ажилтныг 2023 оны 11 дүгээр сард тус байгууллагаас зохион байгуулж 1 өдрийн цалинтай чөлөө олгож “Рехамед” эмнэлэгт холбогдох эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан.</p>	100%

					<p>2. Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Стресс менежмент” сэдвээр Монголын Сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн тэргүүн Н.Алтанзул, “Хүмүүс хоорондын харилцаа, харилцан хандлага” сэдвээр Franklin Covey сургалтын төвийн багш Б.Солонгоо нар нийт ажилтан албан хаагчдад хичээл заалаа.</p> <p>Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 онд шинээр баталсантай холбогдуулан хуульд нийцүүлэн байгууллагын “Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2023 оны 10 дугаар сард шинэчлэн боловсруулж баталсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон ёс зүйн шинэ дүрмийг танилцуулах зорилгоор байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад менежер Б.Зоригоо сургалт зохион байгуулсан.</p> <p>Архив, бичиг хэргийн ажилтан Р.Мөнхбаяр НЗДТГ-аас манай байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн үнэлгээний багийн гишүүдийн зөвлөмжийн дагуу албан хэрэг хөтлөлт, архивын хууль тогтоомжууд, Баримт бичгийн стандарт (MNS5140:2021)-ын талаарх сургалтыг ажилтан албан хаагчдын дунд зохион байгууллаа.</p> <p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, стандартууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нэг бүрийн хамгаалах хэрэгслүүд, анхан шатны тусламж” сэдвээр хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн давтан зааварчилгаа авдаг жолооч, ачигч, агуулахын нярав, үйлчлэгч нарт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Хүнс гэж юу вэ, хүнсний чанар, эрүүл ахуйн тухай суурь ойлголтууд” сэдвээр эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд хүнсний</p>
--	--	--	--	--	--

						<p>чанар, эрүүл ахуйн асуудлаар нийт ажилтан, албан хаагчдын дунд сургалт зохион байгуулсан.</p> <p>Татвар, нийгмийн даатгал, цалин хөлстэй холбоотой мэдээлэл өгөх сургалтыг байгууллагын ажилтан, албан хаагчдад ерөнхий нягтлан бодогч Ш.Отгонжаргал хийлээ. Байгууллагын ажилчдын хүүхэд, багачуудад зориулсан 4 удаагийн шатрын сургалтыг тус байгууллагын ачигч, шатрын спортын 1-р зэрэгтэй тамирчин Д.Өлзийсайхан зохион байгуулсан.Тус сургалтад ажилтан албан хаагчдын 10 хүүхэд хамрагдсан.</p> <p>Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад суусан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификатад авсан. Шинээр ажилд орсон архив, бичиг хэргийн ажилтан Б.Эрдэнэчимэг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгож, АЗ гэрчилгээ авах сургалтад 2023 оны 12 дугаар сарын 6-наас 8-ны өдрүүдэд суусан.</p>	
2.5	<p>Арга хэмжээ: Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль, шүүхийн байгууллагад хэрэг, маргаан гарсан тохиолдолд нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр</p>		<p>Хэрэг, маргаан, зөрчилгүй ажилласан тоо</p>	0	0	<p>2023 оны жилийн эцсийн байдлаар хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль, шүүхийн байгууллагад хэрэг, маргаан гарсан тохиолдолд байхгүй байна.</p>	100%

	төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна						
2.6	Арга хэмжээ: Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ		Санал хүргүүлсэн тоо	0	1-ээс багагүй	Хүнсний хангамжийн 4 байгууллагын хамтаар тулгамдаад байгаа Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлын талаар дэлгэрэнгүй тайлбар бүхий санал, хүсэлтийг НЗДТГ, ТЕГ, Нийслэлийн Татварын газар, БСШУЯ зэрэг байгууллагуудад удаа дараа хүргүүлсэн боловч тодорхой шалтгаануудын улмаас шийдэлд хүрээгүй байна.	100%
2.7	Арга хэмжээ: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана		Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчилгүй ажилласан тоо	0	0	Байгууллагын хашааны өмнө байрлах автобусны буудлын дэргэд зөвшөөрөлгүй газарт нууцаар хог хаяж байгаа асуудлыг шийдэхээр Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны Засаг дарга Г.Шүрэнцэцэг болон хэсгийн ахлагч нартай уулзалтыг хийлээ. Дээрх асуудлыг шийдэх ажлын хүрээнд манай байгууллагын хяналтын камерыг хог нууцаар хаяж байгаа талбайг чиглүүлж, бичлэгийг уг ажлыг хариуцсан хорооны ажилтанд өгч арга хэмжээ авсны үр дүнд хог хаягдал хаядаг байдал бүрэн зогссон. Оффисын өмнөх талбайд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хяналтын камер суурилуулсан. 2023 онд ямар нэгэн гэмт, хэрэг зөрчил гараагүй болно.	100%
2.8	Арга хэмжээ: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж,		Жендерийн асуудлаар гарсан зөрчил,	0	0	2023 оны эхний хагас жилд Жендерийн асуудлаар гарсан зөрчил, гомдол байхгүй.	100%

	<p>ялгаварлан гадуурхал гаргалгүй ажиллана</p>		<p>гомдлын тоо</p>		<p>Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” нэртэй “Надаас, танаас, биднээс эхлэлтэй” уриан дор 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулагдаж байгаа нэг сарын аянд тус байгууллагын хамт олон нэгдлээ.</p> <p>Аяны хүрээнд нийт ажилтан албан хаагчдад “Харилцан хүндэтгэе” аяны талаар жендерийн эрх тэгш байдлыг таниулах, хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх үр нөлөө, эмэгтэйчүүдийн манлайлал болон эрэгтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн мэдээллийг нэмэгдүүлэх талаар мэдээ, мэдээллийг байгууллагын ил тод нээлттэй байдлын самбар болон фэйсбүүк хуудсаар хүргэж ажилласан.</p> <p>Тус аяны хугацаанд байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөлөөс санаачлан 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр жендерийн талаарх нийтлэг ойлголт, эрэгтэй эмэгтэй хүмүүс хамтдаа тэгш боломж тэгш харилцаатай ажиллаж амьдрах эерэг хандлагыг бий болгох, жендерийн буруу ойлголтыг арилгах зэрэг нийтлэг асуулт бүхий “Аха” тэмцээнийг нийт ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулж түрүүлсэн ажилтныг дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.</p> <p>Тус байгууллагын зүгээс “Харилцан хүндэтгэе” аяны хугацаанд дээрх нөлөөллийн ажлыг зохион байгуулсны үр дүнд ажилтан албан хаагчдын жендерийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, жендерийн хэвшмэл ойлголтыг арилгахад нөлөө үзүүлсэн.</p>
--	--	--	--------------------	--	---



2.9	<p>Арга хэмжээ: 2022 оны архивын баримтуудыг хууль, журмын дагуу 2023 оны эхний улиралд багтаан ажилтнуудаас бүрдлийг хангуулан хүлээн авч "Байнга", "Түр", "70 жил", "Тусгай төрөл"-өөр ангилан данс бүртгэл үүсгэж, архивлан хадгалж зохих журмын дагуу ашиглана.</p>		<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	<p>2022 онд бүрэн хэрэгжүүлж ажилласан</p>	<p>100%</p>	<p>2022 оны байдлаар захирамжлалын болон дотоодод үүсэж хөтлөгдсөн Байнга хадгалах 22 баримт, 70 жил хадгалах 3 баримт, Түр хадгалах 95 баримт нийт 120 баримтыг 2023 оны 1-р улиралд багтаан бүрэн бүрдэлтэйгээр хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан байна.</p>	<p>100%</p>
2.10	<p>Арга хэмжээ: Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн шинэ хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батална</p>		<p>Журам шинэчлэн батлагдсан байх</p>	<p>0</p>	<p>Журам хэрэгжиж эхэлсэн байх</p>	<p>Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдлын журмыг Хөдөлмөрийн шинэ хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж дуусган 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/21 дугаар тушаалаар баталлаа.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар жолооч, ачигчийн ажилд шинээр орсон 11 ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 стандарт, 2021 оны 11-р сарын 01-ний өдөр батлагдсан "Ачигчийн гараар ачаа өргөх, зөөх, шилжүүлэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа"-г тус тус танилцуулсан. Урьдчилсан зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зуруулж баталгаажууллаа. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа болох өдөр тутмын зааварчилгааг касс, аж ахуйн нярав, агуулахын нярав, жолооч, ачигч, үйлчлэгч, сахиул нарт</p>	<p>100%</p>

					<p>өгч, зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зуруулан ажилд гаргаж байна.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлэх чиглэлээр шинээр аюулыг мэдээлэх журмыг баталж, аюулыг мэдээлэх хуудсыг нэвтрүүлсэн нь үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь эрсдэлийг бууруулах ажлыг шинээр санаачилж хэрэгжүүллээ. Аюулыг мэдээлэх хайрцгийг байршуулсан.</p> <p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, стандартууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нэг бүрийн хамгаалах хэрэгслүүд, анхан шатны тусламж” сэдвээр давтан зааварчилгаа авдаг жолооч, ачигч, агуулахын нярав, үйлчлэгч нарт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Ажилтан албан хаагчдын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн хувцас солих, түр амрах, хооллох зориулалтаар хуучин оффис байсан 2 өрөөг тохижуулж ахуйн байртай болсон.</p> <p>Ажлын тусгай хувцсыг 2023 жилийн эцсийн байдлаар хуваарийн дагуу нийт жолооч, ачигч, үйлчлэгч нарт давхардсан тоогоор 128 ширхэг 7,649,400 төгрөгний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан махны, ногооны, өдөр тутмын гэсэн 3 ээлжийн ажлын хувцсыг захиалгаар хийлгүүлж, ажилтны хэвийн ажиллах нөхцөлийг хангаж ажилласан.</p> <p>Жолооч, ачигч нарт нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох амны хаалт, бээлийгээр өдөр тутам хангаж хэвшсэн. Нурууны хамгаалах бүс PW-80 загварын 11 ширхэг хамгаалах бүсийг шинээр ажилд орсон ажилтанд олгосон, нийт ачигч, жолооч нар шинээр нуруу хамгаалах бүсээр бүрэн хангагдсан.</p>
--	--	--	--	--	---

						Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад суусан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификатыг авсан.	
<b>Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт - Баянзүрх, Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр тасралтгүй, шуурхай ханган нийлүүлж ажиллана.(НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 27 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар дүрэм батлагдсан)</b>							
3.1	Арга хэмжээ: 2023 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-сайтаар нийтэд ил тод зарлан, зохион байгуулна.	Үйл ажиллагааны орлогоос 2,000.0	Хэрэгжилтийн хувь	19 багц бүхий нээлттэй тендер зохион байгуулсан	100%	2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн захирлын А/03 дугаар тушаалаар тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. 02 дугаар сарын 08-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр 19 багц бүхий нэг нээлттэй тендер шалгаруулалтыг нийтэд зарлан зохион байгуулсан. Амжилтгүй болсон багцууд дээр дахин 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 11, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд тус тус нийт 4 удаа тендер шалгаруулалтыг зохион төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж дуусгасан. Шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан амжилттай хэрэгжиж байна.	100%
3.2	Арга хэмжээ: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд дээд газар, албан тушаалтнаас ирүүлсэн чиглэлийн дагуу мод тарих арга хэмжээг зохион байгуулна.	700.0	Арга хэмжээ зохион байгуулсан тоо	2	2	Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын хамт олон Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, Шинэ нисэхийн зам дагуу “Ногоон хэрэм” төслийн талбайд хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр өөрийн хуваарилагдсан талбайд нийт 25 улиас мод	100%

						тарьсан. Мөн “Ногоон хот иргэний оролцоо” сэдэвт намрын мод тарих аянд нэгдэж чиглэл хуваарийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдөр дээрх талбайд 25 улиас мод тарилаа.	
3.3	Арга хэмжээ: Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй биечлэн ажилладаг албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэг, шинжилгээнд жилд 2 удаа хамруулна	1,200.0	Үзлэгт хамрагдсан ажилтны тоо	2 удаагийн үзлэгт давхардсан тоогоор 48	2 удаагийн үзлэгт давхардсан тоогоор 48	БЗД-ийн Эрүүл мэндийн төвтэй хамтын гэрээ байгуулсан гэрээний дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг 2023 оны 03 дугаар сарын 21, 9 сарын 22-ны өдөр тус тус зохион байгуулж, одоо ажиллаж байгаа нийт ажилтан, албан хаагчдыг хамруулж хяналт тавьж, бүртгэл хөтлөн ажиллалаа. Шинжилгээгээр эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй ажилтан байхгүй.	100%
3.4	Арга хэмжээ: Махны шинэлэг байдлыг тодорхойлох багаж (pH metr) болон бүтээгдэхүүний гүний термометр хэмжигч багаж тус тус шинээр худалдан авч, өдөр тутамд ханган нийлүүлэгдэж байгаа мах болон бусад бүх хүнсний бүтээгдэхүүнийг шинжилж, хяналт тавин ажиллаж эхэлнэ.	3,200.0	Худадан авсан багажны тоо	0	2	Махны шинэлэг байдлыг тодорхойлох багаж (pH metr) болон бүтээгдэхүүний гүний термометр хэмжигч багажийг худалдан авахаар судалгааг хийж байна. Тус багажийг импортоор оруулж ирж худалдаалдаг “Цэцүүх трейд”, “Грийн химистри” ХХК-иудаас үнийн санал хүлээн авсны дагуу уг 2 багажийг худалдан авч үйл ажиллагаандаа хэрэглэж эхлээд байна. Хэрэглэж эхэлснээр чанарын шаардлага хангахгүй махыг газар дээрээс нь буцаах, солиулах арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажилладаг давуу талтай болсон.	100%
<b>Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд-</b> Байгууллагын бусад үйл ажиллагаа, үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлж ажиллана.							

4.1.	<p>Арга хэмжээ: 1800-1200 дугаар утас, CallCenter болон иргэд, ААН, харилцагч байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг цахим болон бусад хэлбэрээр хүлээн авч, хуулийн хугацаанд багтаан үндэслэлтэйгээр түргэн шуурхай шийдвэрлэж, хариуг албан ёсоор мэдэгдэн ажиллана.</p>		<p>Ирсэн өргөдөл, гомдлуудыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн хувь</p>	<p>2022 онд өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%</p>	<p>100%</p>	<p>Хагас жилийн байдлаар тус байгууллагад 1800-1200 дугаар утас, CallCenter болон иргэд, ААН, харилцагч байгууллагуудаас өргөдөл, гомдол цахим болон бусад хэлбэрээр ирээгүй байна. Харин байгууллагын ажилчдаас ирсэн дотоодын 16 өргөдөл ирснийг ERP системд бүртгэн, бүгдийг бүрэн шийдвэрлэж хариуг мэдэгдэн ажилласан. Эдгээрээс 15 өргөдөл нь ажил байдлын буюу цалингийн тодорхойлолт авах тухай, нэг нь жолоочийн С ангиллын сургалтад хамрагдаж, төлбөрийг гаргуулах хүсэлт байна.</p>	<p>100%</p>
4.2.	<p>Арга хэмжээ: Шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа цэцэрлэг, ясли, сургууль, эсхүл захирал, эрхлэгч, тогооч, нярвууд нь шинээр томилогдсон цэцэрлэгүүдэд хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хадгалалт, хамгаалал, түүний боловсруулалтад эрүүл ахуйн талаарх зөвлөн туслах үйлчилгээ, арга зүйн зөвлөгөөг очиж үзүүлнэ. Илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь</p>	<p>Үйл ажиллагааны орлогоос 1,200.0</p>	<p>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх цэцэрлэгийн тоо</p>	<p>14</p>	<p>10-аас багагүй</p>	<p>Тайлант хугацаанд 1 дүгээр сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэгт, 2 дугаар сарын 15-ны өдөр 149, 289 дүгээр цэцэрлэгт тус тус менежер, 2 эрүүл ахуйчийн бүрэлдэхүүнтэйгээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Ноцтой зөрчил дутагдал илрээгүй. 2022-2023 хичээлийн жил дуусаж байгаатай холбогдуулан цэцэрлэгүүд хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлгүй байх шаардлагатай байдаг. Иймээс 05 дугаар сарын 22-ноос 31-ний хооронд менежер, эрүүл ахуйн 2 ажилтан, түгээлтийн нярвуудын хамтаар эрсдэлтэй гэж үзсэн 17 цэцэрлэгээр очиж хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах, үлдэгдэлгүй ажиллах, захиалгаа тохируулах зэргээр зөвлөн туслах үйлчилгээг өгч ажилласан.</p> <p>Мөн 10 дугаар сарын 25-ны өдөр “Харилцагч цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний агуулахад зөвлөх үйлчилгээ”-ний ажлын удирдамжийг, ажлын хэсгийн бүрэлдэхүүний</p>	<p>100%</p>

	арилгуулах ажлыг зохион байгуулна.					хамтаар байгууллагын захирал баталсан. Бүрэлдэхүүнд менежер Б.Зоригоо эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд, Б.Болортуяа, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 8-р сар буюу хичээлийн шинэ жил эхэлснээс хойш үйл ажиллагаагаа эхлүүлсэн 7 цэцэрлэг дээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан байна.	
4.3	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг хийж, гарсан үр дүнг дүгнэж түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллана.		Судалгаа зохион байгуулсан тоо	0	1	Байгууллагын үйл ажиллагааны талаарх 8 асуулт бүхий судалгааг харилцагч 18 цэцэрлэгээс түүвэрлэн цахим хэлбэрээр авсан. Уг судалгааны үр дүн, мэдээллийг <a href="https://sudalгаа.gov.mn/">https://sudalгаа.gov.mn/</a> цахим хуудсанд байршуулан ажилласан. Судалгаанаас гарсан үр дүнд шинжилгээ, дүгнэлт хийж цаашдын үйл ажиллагаандаа тооцон ажиллаж байна.	100%
4.4	Арга хэмжээ: Тус байгууллагын дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-өөс хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соёл, урлагаар дамжуулан нийгэмшүүлэх, хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн төлөвшилд харшлах аливаа үйл ажиллагааг үл тэвчих талаар эцэг, эхчүүдийг соён	Үйл ажиллагааны орлогоос 1,300.0	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	2	2	"Хүүхэд бүхэн жаргалтай байг" арга хэмжээг Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооноос 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 13:00 цагт Нийслэлийн ерөнхий боловсролын 148 дугаар сургуулийн гадна талбайд зохион байгуулж, тус хорооны 2000 орчим хүүхэд багачууд оролцлоо. Дээрх хүүхдийн баярт зориулсан арга хэмжээг зохион байгуулахад манай байгууллага хамтарч оролцсон.  2023 оны 09 дүгээр сард байгууллагын ажилчдын 31 хүүхдэд Цэргийн гавъяаны улаан тугийн одонт "Монгол цэргийн музей"-г үзүүлсэн. Тус музейг хүүхдүүд үзсэнээр Монголын төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүх, үе үеийн эх орончдын байгуулсан гавъяатай танилцаж,	100%

	гэгээрүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, хамт олон болох зорилтын хүрээнд холбогдох 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулж ажиллана.					цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн зүйлстэй танилцах ач холбогдолтой байлаа. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс санаачлан манай байгууллагад ачигчаар ажилладаг шатрын спортын 1-р зэрэгтэй тамирчин Д.Өлзийсайханд ажилчдын хүүхэд, багачуудад зориулан шатрын сургалтыг хийж өгөөч гэж хүсэлт тавьсны дагуу 4 удаагийн шатрын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад ажилтан, албан хаагчдын 10 хүүхэд хамрагдсан.	
4.5	Арга хэмжээ: Байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл” нь байгууллагын залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулна.	800.0	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	0	2	Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс дараах 2 арга хэмжээг амжилттай зохион байгуулан ажиллалаа. 1- Нийт ажилтнуудын багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, нийтэч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “АХА” танин мэдэхүйн асуулт, хариултын тэмцээнийг 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. I байранд Менежер Б.Зоригоо, II байранд Жолооч Б.Батзул, III байранд нярав Б.Бат-Эрдэнэ шалгарлаа. 2- 4 дүгээр сарын 07-ны өдөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний нийгэмлэгийн сургагч багш н.Алтанзулыг урьж нийт ажилчдад “Ковидын дараах сэтгэл зүйн эрүүл мэнд, стресс менежмент” сэдвээр сургалтыг орсон. 3. Байгууллагын ажилчдын бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 12-р сард байгууллагын ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээний эрэгтэй төрөлд ачигч Ц.Ням-Очир түрүүлж, түгээлтийн нярав Э.Лхагвасүрэн удаалсан. Харин эмэгтэйчүүдийн төрөлд үйлчлэгч Ш.Оюун-Эрдэнэ түрүүлж, касс, аж ахуйн нярав Б.Баярмаа дэд байр эзэлсэн. Тэмцээнд нийт ажилтан, албан хаагчид идэвхтэй оролцсон.	100%

4.6	<p>“Цахим улаанбаатар” төсөл, “digital first” аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж, мэдээллийг байгууллагын вебсайт, фэйсбүүк хуудсаар сурталчилан ажиллана</p>		Мэдээлэл байршуулсан тоо	0	4-өөс багагүй	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын <a href="http://childfood.ub.gov.mn/">http://childfood.ub.gov.mn/</a> цахим хуудсанд нээлттэй байршуулах 98 шалгуур үзүүлэлтээс манай байгууллагын үйл ажиллагааны онцлогт хамаарах 68 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулж, эхний тайланг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахимаар хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, хэрэглэгчдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нээлттэй ил тод байлгах зорилгоор долоо хоног бүрийн Баасан гарагт “Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан тайлан”-г Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тогтмол хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт, шууд гэрээ, байгууллага албан хаагчийн нөөц боломжид хийсэн холбогдох хууль тогтоомжид нууц ангилалд хамаарахаас бусад өөрт хамаарах судалгаа, мэдээллийг судалгааны нэгдсэн систем (<a href="http://sudalгаа.gov.mn">sudalгаа.gov.mn</a>)-д байршуулсан.</p>	100%
-----	--	--	--------------------------	---	---------------	---	------



4.7	Төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийт цэцэрлэгүүдээс хүлээн авдаг хүнсний бүтээгдэхүүний захиалгыг интернет ашиглан онлайн хэлбэрээр түргэн, шуурхай хүлээн авдаг болох ажлыг харилцагч нийт цэцэрлэг яслийн хамт нэвтрүүлнэ.	1,500.0	Захиалгын системийг хэрэглээнд нэвтрүүлсэн хэрэгжилтийн хувь	0	100%	Байгууллагын цахим хуудсанд захиалгын дэд систем бий болгон хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага болох “Супер ассист систем” ХХК-тай гэрээ байгуулсан. Тухайн онд багтаан ашиглалтад бүрэн оруулахаар ажиллаж байна. Одоогоор систем хөгжүүлэх ажил хийгдэж дуусаад 12-р сарын эхэнд сонгогдсон 5 цэцэрлэгтэй хамтран туршилтыг амжилттай хийгээд байна.	90%
4.8	Арга хэмжээ: Харилцагч нийт цэцэрлэгүүдийн тогооч нарыг хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, чадваржуулах сургалт, арга хэмжээг зохих мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны орлогоос 4,000.0	83 Цэцэрлэгийн тогооч нарын хамрагдсан тоо	0	83	Манай байгууллагаас 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр “Намрын ногоон өдөр-2023” сургалт, арга хэмжээг нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргийн харилцагч 96 цэцэрлэгийн нярав, тогооч нарын дунд хамтатган зохион байгууллаа. Тус арга хэмжээнд харилцагч цэцэрлэгүүдийг төлөөлж 200 хүн оролцсон. Энэ удаагийн арга хэмжээнд оролцогчид нь тус байгууллагатай гэрээний дагуу төмс, хүнсний болон нарийн ногоо бэлтгэн нийлүүлэгч “Эрдэнэ энх трейд” ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн агуулахын үйл ажиллагаатай танилцлаа. Мөн тус компанийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх баг Тэмээтийн хонхор гэх газарт байрлах тариалангийн талбайд очиж хүнсний ногооны тариалалт, хураалт, тээвэрлэлттэй газар дээр нь очиж танилцан зохих онолын болон практик мэдлэг олж аван, санал солилцох уулзалтыг	100%
4.9	Арга хэмжээ: Харилцагч нийт цэцэрлэгүүдийн хүнсний нярвуудад хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, хүүхдийн	Үйл ажиллагааны орлогоос 4,000.0	83 цэцэрлэгийн хүнсний нярвын хамрагдсан тоо	0	83		100%

	хүнсний онцлогийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлж, хөгжүүлэх, чадваржуулах сургалт, арга хэмжээг зохиох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.					зохион байгууллаа. Мөн сургалтаар Монголын Хоол зүй шим судлалын багш нартай хамтран хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, боловсруулах, хүүхдийн хүнсний онцлогийн талаарх мэдлэг олгох сургалтыг явуулсан.  Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсаны дараа байгууллагын 2023 оны төсөв буюу зорилтот түвшинг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраас сургалтын зардлыг хасаж баталсан тул Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тогооч, нярвуудын сургалтыг хамтатган зохион байгуулсан болно.	
4.10	Арга хэмжээ: Гэрээний дагуу ханган нийлүүлэлт хийдэг аж ахуйн нэгжүүдэд зориулан сургууль цэцэрлэгийн насны хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, хамгаалал түгээлтийн стандарт шаардлага онцлогийн талаарх сургалт зөвлөгөөнийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны орлогоос  1,500.0	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	0	13	Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсаны дараа байгууллагын 2023 оны төсөв буюу зорилтот түвшинг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраас сургалтын зардлыг хасаж баталсан. Иймд уг сургалтыг зохион байгуулах санхүүгийн эх үүсвэргүй болж зогсоосон.	0%
4.11	Арга хэмжээ: Харьяалагдах төрийн архивын	200.0	Сургалтад хамрагдсан	0	10	2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын	

	байгууллагад санал хүргүүлж, захиргааны ажилтнуудад ERP, EDoc систем ашиглалтын тараах сургалтыг зохион байгуулна.		ажилтны тоо			хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төвд хандан ERP, EDoc систем ашиглалтын тараах сургалтыг авах тухай хүсэлт илгээсэн. Хүсэлтийн дагуу НЗДТГ-ын ТЗУХ-ийн ХНХТөвийн мэргэжилтэн Д.Буяндэлгэр бидэнтэй утсаар холбогдож уг сургалтад манай байгууллагыг 8 дугаар сард багтаан хамруулах болсныг мэдэгдээд байсан боловч ажлын ачааллаас шалтгаалан хойшилсон. Иймд Нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн Ч.Бямбадолгорт хандан хүсэлт гаргасны дагуу 11 дүгээр сарын 08-ны өдөр уг сургалтыг байгууллагын захиргааны ажилтнуудад орж, зохих мэдлэгийг олж авлаа.	100%
4.12	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь багтаан хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор бодитоор шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллана.		Ирсэн зөрчлийн мэдээллийг шийдвэрлэсэн хувь	0	100%	Нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирсэн зөрчлийн мэдээ байхгүй байна.  Харин өөрсдийн санаачилгаар байгууллагын хашааны өмнө байрлах автобусны буудлын дэргэд зөвшөөрөлгүй газарт нууцаар хог хаяж байгаа асуудлыг шийдэхээр Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны Засаг дарга Г.Шүрэнцэцэг болон хэсгийн ахлагч нартай уулзалтыг хийлээ. Дээрх асуудлыг шийдэх ажлын хүрээнд манай байгууллагын хяналтын камерыг хог нууцаар хаяж байгаа талбайг чиглүүлж, бичлэгийг уг ажлыг хариуцсан хорооны ажилтанд өгч арга хэмжээ авсны үр дүнд худалдаачид, иргэд хог хаядаг байдал бүрэн зогссон.	100%
4.13	НИТХ-ын 2022 оны 18/26 дугаар тогтоолоор батлагдсан 9 бүлгийн 38 стандартаас UCS 1104B “Төрийн байгууллагын гадна	1,500.0	Стандартын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хувь	0	60%	UCS 1104B “Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” стандартаас Тус байгууллагад хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Байгууллагын хашаанд ургадаг 6 улиас модны мөчрийг холбогдох стандартын дагуу тайрсан. Улиас модыг тайрснаар модны цаашдын	

орчны ерөнхий шаардлага” стандартыг өөрийн байгууллагын бололцооны хэмжээнд хэрэгжүүлж ажиллана.					ургалтад сайн байдаг бөгөөд 6-р сард улиасны унгарил үүсэхгүй, байгууллагын гадна орчны өнгө үзэмжид эерэг нөлөө үзүүлдэг давуу талтай болсон.	80%
Нийт						93.1%

Төлөвлөгөөг хянасан:

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

.....  
(гарын үсэг)

Х.НЯМБААТАР

(огноо)

.....

Тэмдэг


Төлөвлөгөө тайлагнасан:

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ



Тэмдэг

**Төсвийн Шууд захирагч**

  
.....  
(гарын үсэг)

Г.МӨНХЗУЛ

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр